

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 20/6

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүү, заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийн талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдааны эхний хэсэгт макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдалд гарч буй гол өөрчлөлтүүд, КОВИД-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

Цар тахал дотоодод дэгдсэний улмаас 11-р сарын 12-ноос хатуу хөл хорио тогтоож, зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнэ бага зэрэг өссөн нь инфляц энэ оны эцэст нэмэгдэх нөлөөг үзүүлж байна. Гэсэн хэдий ч инфляцад үзүүлэх эдийн засгийн идэвхжлийн нөлөө ирэх саруудад буурч, инфляц зорилтот түвшнээс доогуур байх хандлага хэвээр хадгалагдаж байна. Харин 2021 онд эдийн засгийн идэвхжил саарч байгаагаас үүдэн инфляц өмнөх төсөөллөөс буурахаар байгаа бөгөөд оны сүүлийн хагаст эдийн засгийн өсөлт сэргэн, эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэн дунд хугацаанд зорилтот түвшин (6%)-ий орчимд тогтворжих төлөвтэй байгааг онцоллоо.

МБГ-аас 2020 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл огцом муудах төлөвтэй байгааг танилцууллаа. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө 3-р улиралд хүлээлтээс өндөр байсны зэрэгцээ 11-р сард халдвар дотооддоо тархаж, хатуу хөл хорио тогтоосон нь өсөлтийн төсөөлөл буурах гол шалтгаан болсныг дурдав. Тодруулбал, эдийн засгийн өсөлт 3-р улиралд хүлээлтээс доогуур гүйцэтгэлтэй гарахад Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө болон төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутуу гүйцэтгэлтэй байснаас шалтгаалан барилга, боловсруулах, худалдаа, тээвэр, уул уурхайн салбарын үйлдвэрлэл хүлээлтэд хүрч нэмэгдээгүй нь нөлөөлсөн. Түүнчлэн, шинэ корона вирусын халдвар дотоодод тархаж бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, уг арга хэмжээний үргэлжлэх хугацааг цаашид сунгах магадлалтай байгаа нь уул уурхай, хөдөө аж ахуй, мэдээлэл холбооны салбараас бусад салбаруудад сөргөөр нөлөөлөхөөр байна. Харин уул уурхайн бүтээгдэхүүний экспорт оны

сүүлийн улиралд харьцангуй тогтвортой үргэлжилж, тээврийн салбарын үйлдвэрлэл буурахгүй гэж үзжээ. Ирэх онд гадаад эрэлт сайжрах, Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж нэмэгдэх нөлөөгөөр уул уурхайн салбар идэвхжих хэдий ч хөл хорионы дэглэм, вирусын тархалтын улмаас дотоод эдийн засаг сэргэх хугацаа удааширч, эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурах хүлээлттэй байгааг танилцуулав.

M2 мөнгөний жилийн өсөлт 2020 оны 2 дугаар улирлаас эхлэн алгуур нэмэгдэн 10-р сард 10.1 хувь болж сэргэсэн бөгөөд үүнд төсвийн алдагдлыг Засгийн газар банкны систем дахь нөөцөөсөө санхүүжүүлж байгаа нь голлон нөлөөлжээ. Мөн банкны системийн зээлийн өсөлт сул хэвээр байгаа боловч тогтворжих хандлагатай байгааг онцлов. Түүнчлэн, банкны системийн хугацаа хэтэрсэн зээлийн дүн нэмэгдэхэд боловсруулах, уул уурхай болон бусад үйлчилгээний салбарын хугацаа хэтэрсэн зээл голлон нөлөөлснийг дурдав.

Дэлхийн эдийн засаг сэргэх хандлага ажиглагдаж байна. Гэвч цаашид Ковид-19 цар тахлын дараагийн давалгаа үүсэх эсэх, үүнтэй холбоотойгоор улс орнууд ямар арга хэмжээ авахаас хамаараад гадаад эрэлтийн төлөвд тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Манай орны экспортын гол түүхий эдийн үнийг авч үзвэл Ковид-19 цар тахлын эсрэг зарим вакцины туршилтууд 90-ээс дээш хувийн үр дүнтэй байгаа тухай мэдээ түүхий эдийн зах зээлд оролцогчдод эерэг дохиог өгч, зэс, төмрийн хүдрийн үнийн төсөөлөл нэмэгдсэн. Харин БНХАУ-ын кокс, коксжих нүүрсний эрэлт удаашрах төлөвтэй болсон тул нүүрсний үнийн төсөөлөл бага зэрэг буурсан болохыг танилцуулав.

Төлбөрийн тэнцлийн 2020 оны төсөөлөл өмнөхөөс сайжирсан ч алдагдалтай гарах төлөв хэвээр байна. Эхний 9 сарын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл болон 10-р сарын гадаад цэвэр нөөцийн өөрчлөлтөөс харахад төлбөрийн тэнцэл энэ оны эхний 10 сард 290 орчим сая ам.долларын алдагдалтай гарахаар байна. Тооцооллоор оны сүүлийн саруудад экспорт харьцангуй тогтвортой үргэлжилж, гадаад шууд хөрөнгө оруулалт, засгийн газрын гадаад санхүүжилт гадаад валютын орох урсгалд эерэгээр нөлөөлөх бол хүнсний импорт нэмэгдэх, хувийн секторын гадаад санхүүжилт буурч, төлбөрийн тэнцэл энэ онд нийт 110 сая ам.долларын алдагдалтай байх төлөвтэй байна.

Үргэлжлүүлээд, ЗБН-ийн хувийг төгрөгийн эх үүсвэрийн хувьд бууруулах бодлогын арга хэмжээ нь банкуудын ЗБН-ийн хангалт, илүүдэл нөөцөд хэрхэн нөлөөлөх тооцооллыг танилцуулав. Эдийн засаг хүндэрсэн энэ үед хүү буурах

зах зээлийн нөхцлийг бүрдүүлэх, банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг бууруулах арга хэмжээ тохиромжтой болохыг онцлов.

Танилцуулгын дараагийн хэсэгт макро зохистой бодлогын хүрээнд эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэх тухай танилцуулгыг хийв. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэлийн хувьд: 1) Монгол Улс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, 2) МБХ-ны өмнөх шийдвэрүүдийн хүрээнд хугацааны сунгалт хийсэн зээлдэгчдийн хувьд дахин хүндрэлд ороход хугацааг сунгах боломж хязгаарлагдмал байгаа, 3) МБХ-ны 2020 оны 4, 8 дугаар сарын ээлжит бус хурлаар хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргасан бөгөөд бодлогын хэрэгжих хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусахаар хүлээгдэж байсан зэрэг нь уг асуудлыг хэлэлцэх үндэслэл болсон юм.

Энэхүү бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зээлдэгчийн санхүүгийн чадавхийг зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай нийцүүлэх; эргэн төлөлтөд хүндрэл учирсан саруудад үндсэн болон хүүний төлбөрийг хойшлуулснаар банкны системийн хэрэглээний зээлийн эрсдэлийг бууруулах; зээлдэгчийн ирээдүйн зээлжих чадварыг хадгалах; санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах зэрэг давуу талууд үүснэ.

Мөнгөний бодлогын газраас бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 7 хувьд хүргэх, ЗБН-ийн хувь хэмжээг төгрөгийн эх үүсвэрийн хувьд 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувь болгох, макро зохистой бодлогын хүрээнд эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэх бодлогын багц санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

МБХ-ны гишүүдийн хувьд Ковид-19 цар тахал дотоодод тархсанаар эдийн засгийн үйл ажиллагаа богино хугацаанд хумигдаж, зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсэхээр байгаа одоогийн нөхцөлд дээрх багц бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь эдийн засаг, банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэйг онцлов. Эдийн засгийн өсөлтийн төлөв огцом буурсан, инфляц бага түвшинд хадгалагдаж, гадаад орчны дарамт харьцангуй буурсан учраас эдийн засаг, бизнесийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулах нь зүйтэй гэсэн шийдвэрт санал нэгдсэн

бөгөөд бодлогын хүүг 1 нэгж хувиар эсвэл 2 нэгж хувиар бууруулах талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

МБХ-ны 1 гишүүн цар тахлын нөхцөл байдлын улмаас эдийн засгийн үйл ажиллагаа удаан хугацаанд хумигдаж, зээл тасалдах нөхцөл үүсэх нь мөнгөний бодлогыг зөөллөсний үр нөлөөг бууруулах тул энэ удаад бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 7 хувьд хүргэх саналыг гаргав. Харин бусад гишүүдийн зүгээс инфляц бага түвшинд хадгалагдахаар байгаа нөхцөлд мөнгөний бодлогын төлөвийг илүү зөөлрүүлэн цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулж, эдийн засгийг дэмжих нь зүйтэй гэж үзлээ. Иймд бодлогын хүүг энэ удаад 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэн, цаашид гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан бодлогын орон зайг тодорхой түвшинд хадгалах шаардлага бий гэдэгтэй гишүүд санал нэгдэв.

Төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж, 6 хувьд тогтоох шийдвэр нь банкуудын чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, санхүүгийн зуучлалыг дэмжих нөлөөтэй тул гишүүд 100 хувийн саналаар дэмжив. Мөн эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг үргэлжлүүлэх нь цар тахлын өрхийн хэрэглээнд үзүүлэх сөрөг нөлөө, зээлдэгчийн санхүүгийн дарамтыг зөөлрүүлэх, улмаар банкны системийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхийг онцоллоо.

Хуралдааны төгсгөлд мөнгөний бодлогын хэрэгсэл болох репо арилжааг зохион байгуулахад шаардлагатай зарим арга хэмжээний талаар Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газраас танилцуулж, хэлэлцүүлэв.

МБХ-ны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар 2 хүртэл жилийн хугацаатай урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх шийдвэрийг гаргасан. Үүнтэй холбоотойгоор МБЕ-ийн тушаалаар ажлын хэсэг байгуулж, үнэт цаасжуулах компанийг тус ажлын хэсгээс сонгон, энэ оны 11 дүгээр сард багтан үнэт цаасжуулах ажил хийгдэнэ гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байсан боловч хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор Тусгай Зориулалтын Компани (ТЗК) арилжааны банкуудад очиж зээлийг шалган, үнэт цаас гаргах ажиллагаанд хүндрэл үүсээд байна. Иймд тус санхүүжилтийг хөл хорионы нөхцөлтэй уялдуулан шинэчлэн хийхээр төлөвлөснийг танилцуулав. Үүнд; 1) Хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас (ХЗБҮЦ) гарах хүртэл Монголбанкнаас гаргасан барьцаа хөрөнгийн жагсаалт дахь үнэт цаасыг барьцаалан репо арилжааг банкуудтай хийх, 2) Монголбанкнаас тогтоосон

шалгуурыг хангасан зээлийг дахин санхүүжүүлэхэд эх үүсвэрийг ашиглаж болох, 3) дахин санхүүжүүлсэн зээлийг ТЗК үнэт цаасжуулах бөгөөд хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас бэлэн болмогц банкуудын барьцаа хөрөнгийг солих саналыг гаргалаа. Энэхүү арга хэмжээ нь жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн өртгийг бууруулан дотоод эдийн засгийн уналтыг сааруулах, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх зорилготой болохыг дурдав.

МБХ-ны гишүүд репо арилжааг дээрх байдлаар зохион байгуулж ажиллахыг дэмжиж байгаагаа илэрхийлээд аливаа төрлийн гажуудал, сөрөг нөлөө үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллахыг сануулав.

Ийнхүү Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн ээлжит бус хуралдаанд нийт 6 гишүүн оролцсоноос 5 гишүүн бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх, 1 гишүүн 1 нэгж хувиар бууруулж 7 хувьд хүргэх саналыг дэмжлээ. Төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг бууруулах, эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг үргэлжлүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх саналыг МБХ-ны гишүүд 100 хувь дэмжиж, бодлогын багц шийдвэр гаргав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлаар:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
3. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргалаа.